



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/156/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.08.09 № 20

танай _____ ны № _____ т

АЙМГИЙН ХӨГЖИМТ ЖҮЖГИЙН
ТЕАТРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ХАЛИУНАА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь батлагдсан орон тоог 7 орон тоогоор бууруулж цалингийн зардлыг 80.9, ажил олгогчоос олгох шимтгэлийн зардлыг 12.9, тэтгэмжийн зардлыг .0.2 сая төгрөгийг тус тус хэмнэж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тус байгууллага нь өөрийн үйл ажиллагааны уран бүтээлийн орлогын төлөвлөгөөг төлөвлөж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9-д "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-д "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр

006020032

нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх,” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 3 зорилтын хүрээнд 29 ажил төлөвлөснөөс 24 арга хэмжээ нь биелж 5 арга хэмжээ нь биелэгдээгүй, биелэлт 63.1 хувьтай үнэлэгдсэн байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



~~Б.ЭРДЭНЭ~~

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>227,838,011.36</u>	<u>377,277,067.46</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	97,788,043.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	97,788,043.00
3121	Төгрөг	-	97,788,043.00
31211	Төрийн сангийн харилцах	-	97,788,043.00
35	БАРАА МАТЕРИАЛ	227,838,011.36	279,489,024.46
351	Түүхий эд материал	8,694,670.60	8,528,370.60
35110	Тусгай зориулалттай материал	8,694,670.60	8,528,370.60
35300	Бэлэн бүтээгдэхүүн	176,971,746.50	204,202,663.30
354	Хангамжийн материал	42,171,594.26	66,757,990.56
35410	Бичиг хэргийн материал	2,931,890.00	3,897,630.00
35420	Аж ахуйн материал	14,763,760.60	16,063,300.60
35430	Сэлбэг хэрэгсэл	750,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	969,000.00	1,450,000.00
35450	Барилгын засварын материал	2,911,970.00	20,588,370.00
35470	Бусад хангамжийн материал	19,844,973.66	24,758,689.96
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>361,461,150.81</u>	<u>398,981,465.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	361,461,150.81	398,981,465.27
392	Биет хөрөнгө	307,151,150.81	344,671,465.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	972,826,630.00	972,826,630.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(741,174,662.88)	(752,673,232.92)

39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,140,000.00	81,840,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(97,140,000.00)	(81,840,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,189,580.00	20,779,080.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,421,799.76)	(7,567,386.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,134,851.60	93,134,851.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,315,461.70)	(60,035,663.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	168,511,320.00	242,299,620.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(149,599,306.45)	(164,092,432.96)
393	Биет бус хөрөнгө	54,310,000.00	54,310,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	54,310,000.00	54,310,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>589,299,162.17</u>	<u>776,258,532.73</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>135,653.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	135,653.00	-
413	Өглөг	135,653.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	135,653.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>589,163,509.17</u>	<u>776,258,532.73</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	589,163,509.17	776,258,532.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	547,647,331.04	547,647,331.04
51101	Өмч: - төрийн	547,647,331.04	547,647,331.04
512	Хуримтлагдсан үр дүн	(301,442,150.26)	(114,347,126.70)
51210	Өмнөх үеийн үр дүн	(301,442,150.26)	(301,442,150.26)
51220	Тайлант үеийн үр дүн	-	187,095,023.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	342,958,328.39	342,958,328.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>589,299,162.17</u>	<u>776,258,532.73</u>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	801,613,000.00	989,034,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,243,000.00	109,739,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,243,000.00	109,739,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,243,000.00	109,739,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,243,000.00	16,049,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		93,690,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	796,370,000.00	879,294,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	796,370,000.00	123,175,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	791,570,000.00	108,103,500.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	4,800,000.00	660,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	14,411,900.00
1330	Төсвийн захирагчдаас	-	756,119,400.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	756,119,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	835,461,867.55	801,939,176.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	835,461,867.55	801,939,176.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	704,892,551.55	797,777,255.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	508,798,869.00	526,701,377.00
210101	Үндсэн цалин	407,605,660.00	434,218,299.00
210102	Нэмэгдэл	84,997,709.00	36,590,583.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,195,500.00	14,034,000.00
210104	Урамшуулал	-	41,858,495.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,896,012.00	64,457,993.00

210201	Тэтгэврийн даатгал	46,354,636.00	44,831,176.80
210202	Тэтгэмжийн даатгал	5,176,248.00	5,280,427.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,100,670.00	4,224,341.82
210204	Ажилгүйдлийн даатгал	933,145.00	916,040.44
210205	Эрүүл мэндийн даатгал	9,331,313.00	9,206,006.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,810,147.00	91,673,662.00
210301	Гэрэл, цахилгаан	2,810,762.00	2,546,346.00
210302	Түлш, халаалт	57,829,275.00	85,587,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,170,110.00	3,540,116.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,505,424.41	9,155,726.90
210401	Бичиг хэрэг	520,000.00	1,714,500.00
210402	Тээвэр, шатахуун	930,000.00	1,359,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,170,480.00	1,021,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	727,700.00	473,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500.00	557,360.00
210408	Бараа материал акталсны зардал	6,154,744.41	4,029,966.90
2105	Нормативт зардал	449,960.00	222,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	449,960.00	222,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,987,850.00	5,309,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	246,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,000.00	-
210604	Урсгал засвар	4,729,850.00	5,309,950.00
2107	Томилолт, зочны зардал	1,016,000.00	1,568,000.00
210702	Дотоод албан томилолт	1,016,000.00	1,568,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,332,040.00	37,568,685.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,392,461.00	37,568,685.00
210803	Даатгалын үйлчилгээ	298,775.00	-

210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
210807	Газрын төлбөр	100,804.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,096,249.14	61,119,161.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	459,900.00	9,359,976.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,636,349.14	51,759,185.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,569,316.00	4,161,921.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,959,498.00	3,946,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,409,498.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,550,000.00	3,946,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,609,818.00	215,921.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,609,818.00	215,921.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(33,848,867.55)</u>	<u>187,095,023.56</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	55,369.68	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	55,369.68	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	55,369.68	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(33,793,497.87)</u>	<u>187,095,023.56</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>801,613,000.00</u>	<u>895,344,200.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>5,243,000.00</u>	<u>16,049,400.00</u>

120	Нийтлэг татварын бус орлого	5,243,000.00	16,049,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,243,000.00	16,049,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,243,000.00	16,049,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	796,370,000.00	879,294,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	796,370,000.00	123,175,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	791,570,000.00	108,103,500.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	4,800,000.00	660,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	14,411,900.00
1330	Төсвийн захирагчдаас	-	756,119,400.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	756,119,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	800,421,000.00	785,966,657.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	800,421,000.00	785,966,657.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	669,851,684.00	781,804,736.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	508,663,216.00	526,837,030.00
210101	Үндсэн цалин	407,605,660.00	434,353,952.00
210102	Нэмэгдэл	84,862,056.00	36,590,583.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,195,500.00	14,034,000.00
210104	Урамшуулал	-	41,858,495.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,896,012.00	64,457,993.00
210201	Тэтгэврийн даатгал	46,354,636.00	44,831,176.80
210202	Тэтгэмжийн даатгал	5,176,248.00	5,280,427.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,100,670.00	4,224,341.82
210204	Ажилгүйдлийн даатгал	933,145.00	916,040.44
210205	Эрүүл мэндийн даатгал	9,331,313.00	9,206,006.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,810,147.00	91,673,662.00
210301	Гэрэл, цахилгаан	2,810,762.00	2,546,346.00

210302	Түлш, халаалт	57,829,275.00	85,587,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,170,110.00	3,540,116.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,228,190.00	6,314,700.00
210401	Бичиг хэрэг	472,000.00	1,039,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,324,000.00	2,794,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,072,690.00	1,021,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,139,300.00	410,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	220,200.00	1,050,000.00
2105	Нормативт зардал	789,400.00	752,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	789,400.00	752,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,584,000.00	5,205,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	636,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,013,400.00
210604	Урсгал засвар	4,948,000.00	4,191,850.00
2107	Томилолт, зочны зардал	1,016,000.00	1,568,000.00
210702	Дотоод албан томилолт	1,016,000.00	1,568,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,532,429.00	64,553,825.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,592,850.00	64,553,825.00
210803	Даатгалын үйлчилгээ	298,775.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
210807	Газрын төлбөр	100,804.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	332,290.00	20,441,676.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	332,290.00	20,441,676.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,569,316.00	4,161,921.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	99,959,498.00	3,946,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,409,498.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,550,000.00	3,946,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,609,818.00	215,921.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,609,818.00	215,921.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,192,000.00</u>	<u>109,377,543.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,192,000.00	11,589,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,192,000.00	11,589,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,192,000.00	11,589,500.00
222001	Тоног төхөөрөмж	-	10,089,500.00
223001	Бусад хөрөнгө	1,192,000.00	1,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,192,000.00)</u>	<u>(11,589,500.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	97,788,043.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	97,788,043.00

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-

C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,647,331.04	342,958,328.39	(301,442,150.26)	-	589,163,509.17
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	547,647,331.04	342,958,328.39	(301,442,150.26)	-	589,163,509.17
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	187,095,023.56		187,095,023.56
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,647,331.04	342,958,328.39	(114,347,126.70)	-	776,258,532.73

ТГ

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	847297400.00	785966657.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	847297400.00	785966657.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	846529400.00	781804736.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	607835700.00	526837030.00
210101	Үндсэн цалин	470935700.00	434353952.00
210102	Нэмэгдэл	82713000.00	36590583.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20328000.00	14034000.00
210104	Урамшуулал	33859000.00	41858495.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77452200.00	64457993.00
210201	Тэтгэврийн даатгал	52667600.00	44831176.80
210202	Тэтгэмжийн даатгал	6196200.00	5280427.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	4956900.00	4224341.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1239200.00	916040.44
210205	Эрүүл мэндийн даатгал	12392300.00	9206006.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80513800.00	91673662.00
210301	Гэрэл, цахилгаан	2675000.00	2546346.00
210302	Түлш, халаалт	74888800.00	85587200.00
210303	Цэвэр, бохир ус	2950000.00	3540116.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4443800.00	5844700.00
210401	Бичиг хэрэг	572300.00	1039300.00
210402	Тээвэр, шатахуун	1324300.00	2794000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,147,200.00	1,021,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,150,000.00	410,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,000.00	1,050,000.00
2105	Нормативт зардал	789,100.00	752,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	789,100.00	752,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,700,000.00	5,205,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	1,013,400.00
210604	Урсгал засвар	1,700,000.00	4,191,850.00
2107	Томилолт, зочны зардал	1,600,000.00	1,568,000.00
210702	Дотоод албан томилолт	1,600,000.00	1,568,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,389,000.00	64553825.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,389,000.00	64553825.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,805,800.00	2044167600
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,805,800.00	20441676.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768,000.00	3946000.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	768,000.00	394600000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	3946000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	11,589,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	11,589,500.00
222001	Тоног төхөөрөмж	-	10,089,500.00
223001	Бусад хөрөнгө	-	1,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	852,940,400.00	124,152,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	755,351,400.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	755,351,400.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	97,589,000.00	108,103,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	97,589,000.00	108,103,500.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	16,049,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	16,049,400.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		97,788,043.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	56	49
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	46	39
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10

650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,071,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,071,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,896,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	470,000.00
210402	Тээвэр, шатахуун	470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,575,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,575,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,851,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,851,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,175,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,175,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,175,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Хөгжимт жүжгийн театрын нь 2022 онд “Ард иргэдийнхээ соёлын хэрэгцээг бүрэн хангаж, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлж урлагийн боловсрол олгох, орчин үеийн шаардлагад нийцсэн удирдлагын чадварлаг тогтолцоотой баг бүрдүүлж үндэсний хэмжээнд өрсөлдөхүйц чанартай уран бүтээл, уран бүтээлчдийг төрүүлэх” гэсэн байгууллагын эрхэм зорилго тавьж ажиллажээ. Тус онд доорх гурван зорилт тавьсан байна. Үүнд:

1. Иргэд олон нийтийн соёл урлагийн эрэлт хэрэгцээг хангах
2. Соёл урлагийн мэргэжлийн түвшин, хамрах хүрээг өргөжүүлэх
3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх

Тухайн жил 3 зорилтын хүрээнд 29 ажил төлөвлөснөөс 24 арга хэмжээ биелж 5 арга хэмжээ нь биелээгүй, 63.1 хувиар аймгийн Соёл урлагийн газрын даргаар дүгнүүлэн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Соёлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй*, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод хяналттай холбоотойгоор байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнтэй хийсэн эсэхийг шалгахгаар горим хэрэгжүүлсэн.

Горим сорилоор тооллогын баримт материалтай танилцахад жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/29 тоот тушаалаар 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр томилж ажилласан байна.

Бараа материалын тодруулга тайлангийн уран бүтээлчдийн хувцасны 176.9 сая төгрөгийн бүртгэлийг эм боох материалын дансанд бүртгэн санхүүгийн тодруулга тайланд тайлагнаж, тооллого явуулсныг бэлэн бүтээгдэхүүний данс бүртгэлд бүртгүүлэн тайлагнуулсан.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл/мөнгөн* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь НБББББ-ыг шинэчлэн батлаагүй, аймгийн ЗД-ын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ыг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн байна*.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөгжимт жүжгийн театрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг шинэчлэн батлаагүй 2020 онд баталж гаргасан НБББББ-ийг мөрдөж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 186.9 сая төгрөгөөр буюу 24.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	97788.0	97788.0
Авлага	0	0	0
Бараа материал	227838.0	279489.0	51651.0
Үндсэн хөрөнгө	589299.2	776258.5	186959.3
Нийт хөрөнгө	817137.2	1055747.5	238610.3
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	547647.3	547647.3	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	589299.2	776258.5	186959.3

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 51651.0, үндсэн хөрөнгө 186959.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 756.2, орон нутгийн төсвөөс 87.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөж нийт зарлагыг 843.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслөөр улсын төсвөөс 709.5, орон нутгийн төсвөөс 108.1 сая төгрөгөөр буюу улсын төсвийн дүн 46.7 сая төгрөгөөр буурч, орон нутгийн төсөв 21.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2022 оны 01 дүгээр сараас 04 дүгээр сар хүртэл үйлчилгээний ажилчдын цалин орон нутгийн төсөв рүү шилжсэнтэй холбон үзэж байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийг жилийн эцэст төсөвт тодотгол хийгдээгүй улсын төсвөөс 756.1, орон нутгийн төсвөөс 108.1, нэмэлт дансаар аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөөс 0.6, орон нутгийн хөгжлийн сангаас 14.4, өөрийн үйл ажиллагааны орлого 16.0 сая төгрөг буюу нийт 895.3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Гүйцэтгэлээр 785.9 сая төгрөгийн зарцуулж үлдэгдэл 98.0 сая төгрөгөөс 0.2 сая төгрөгийн тогтмол зардлын үлдэгдлийг төсөвт төвлөрүүлж, үйл ажиллагааны зардлын 97.8 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 785.9 сая төгрөг буюу 87.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 97.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	810213.8	717466.8	92747.0	88.5
2	Уран бүтээл хийх	47389.0	64553.8	-17164.8	136
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	768.0	3946.0	-3178.0	100

Дээрх үзүүлэлтээр уран бүтээлийн 17.1, ажил олгогчоос олгох тэтгэмжийн 3.1 сая төгрөг нь нэмэлт дансны санхүүйлт болон өөрийн орлогоос зарцуулагдсан дүнгээр гүйцэтгэлийг нэмэгдэж харуулсан болно.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс “Хангинахын шугуй” арга хэмжээнд оролцсон уран бүтээлчдийн хоолны зардалд 0.6, Орон нутгийн хөгжлийн сангаас 14.4 сая төгрөгийг Аймгийн засаг даргын 2022 оны А/420, А/478, А/480 тоот захирамжийн дагуу “Аймгийн баяр наадам”-ын үйл ажиллагааны зардалд 7.5, “Айраг наадам”-ын зардалд 3.7, төрийн албан хаагчийн сарын аяны хүрээнд зохион байгуулсан “БАТАК-2022” тэмцээний зардалд 3.2 сая төгрөгийг тус тус нэмэлт дансаар дамжуулан зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 791.7 сая төгрөгөөс 75 хувиар буюу 11.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь 56 орон тооноос 7 орон тоог бууруулж цалингийн зардлыг 80.9, ажил олгогчоос олгох шимтгэлийн зардлыг 12.9, тэтгэмжийн зардлыг .0.2, өөрийн орлогын үлдэгдэл 3.5 сая төгрөгийг тус тус хэмнэж ажилласан байна.

Мөн төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор нийт 33 горим сорил хэрэгжүүлж баримтжуулан ажиллалаа.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд 164 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд бүрэн мэдээлж ажиллажээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь тэмцээн уралдааны зардлын 180.0 мянган төгрөгийн шагналын мөнгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт өгөхөөр шийдвэрлэв.

Томилолтын хоногийг илүү тооцож 64.0 мянган төгрөг олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт өгөхөөр шийдвэрлэв.

Байгууллагын даргын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн Б/30 тоот тушаалаар баталсан цалингийн нэмэгдлийг 153.1 мянган төгрөгөөр дутуу олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт өгөхөөр шийдвэрлэв.

Бараа үйлчилгээний бусад зардлаас 735.9 мянган төгрөгийг шатахууны зардалд бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь заалтын 3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу хэмнэлт үүсгэж ажиллаагүй зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аймгийн Хөгжимт жүжгийн театр нь 2022 оны өөрийн уран бүтээлийн үйл ажиллагааны хүрээний орлогыг төлөвлөж батлуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9-д "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг; 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-д “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар мөнгөн гүйлгээний тайлангийн 11589.5 мянган төгрөгийн хөрөнгийн зардал дансыг буруу илэрхийлсэн алдаа илэрснийг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулж ажилласан.

Шийдвэрлэсэн нь:

Алдааг залруулав.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Аймгийн Хөгжимт жүжгийн театр нь 2022 оны 05 дүгээр сарын 30-ны өдрийн 31 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0

Албан шаардлага	1	242.0	1	242.0	100
Зөвлөмж	1	0	1	0	100
Нийт дүн	2	242.0	2	242.0	100

Хэрэгжээгүй зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өөрийн уран бүтээлийн үйл ажиллагааны орлогыг төлөвлөж ажиллах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 11.6 сая төгрөгийн алдааг залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Үүнд: Мөнгөн гүйлгээний тайланд 11.6 сая төгрөгийн хөрөнгийн зардал данс буруу илэрхийлсэн.

Аудитаар нийт 1.1 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд 0.4 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, .0.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Анхан шатны баримтгүй зарцуулсан 0.2, томилолтын хоног илүү олгосон 0.06, цалингийн нэмэгдлийг дутуу олгосон 0.1 сая төгрөгийн зөрчлүүдэд 3 төлбөрийн акт бичлээ.

5.2 Албан шаардлага

Зориулалт бусаар зарцуулсан 0.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үйл ажиллагааны орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өөрийн байгууллагын үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, батлуулж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагааны орлогыг төлөвлөн батлуулж, төсвийн тухай хуулийн 4.1.9, 6.2.2 дахь заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	/мянган төгрөгөөр/		Зөвлөмж
				Үүнээс Залруулсан	Залруулааг үй	

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгийн зардал данс буруу илэрхийлсэн	1	11589.5					1	11589.5				
Дүн	1	11589.5					1	11589.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өөрийн уран бүтээлийн орлогыг төлөвлөөгүй.	1	0					1	0				
Анхан шатны баримтгүй зарцуулсан.	1	180.0	1	180.0								
Томилолтын хоног илүү олгосон.	1	64.0	1	64.0								
Цалингийн нэмэгдлийг дутуу олгосон.	1	153.1	1	153.1								
Дүн	4	397.1		397.1			1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан.	1	735.9			1	735.9		
Дүн	1	735.9						
Нийт дүн	1	735.9			1	735.9		